



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН 2019





Өмнөх үг	2
М-Си-Эс Группийн тухай	3
Эрхэм зорилго, үнэт зүйлс, баримтлах зарчим	4
Тогтвортой хөгжлийн зорилтууд	6
Нийгмийн төслүүд	7
Эдийн засагт оруулж буй хувь нэмэр	21
Байгаль орчин	22
М-Си-Эс Группийн ажилтнууд	27



М-Си-Эс Групп 2019 онд Нийгмийн хариуцлагын чиглэлээр 90 гаруй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт **17.5 тэрбум** төгрөг зарцуулжээ. Тайлант онд хэрэгжүүлсэн онцлох төслүүдээс дурдвал, Энержи Ресурс компани Улаанбаатар хотын утааг бууруулах ажилд бодит дэмжлэг болгон сайжруулсан түлшний түүхий эд болох Ухаа худагийн угааж баяжуулсан эрчим хүчний 11.7 тэрбум төгрөгийн үнэ бүхий 710,000 тонн нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлсэн. Мөн үндэсний өв соёл, үнэт зүйлсийн бэлгэ тэмдэг болсон түүх соёлын дурсгалыг хадгалж, хамгаалах зорилготой “Өв Эрдэнэ” соёлын өвийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд Чойжин ламын сүм музейн орчны тохижилтын төсөл, Богд хааны ордон музейн уран барилгын эрсдэлийн нөлөөллийн судалгаа, Амарбаясгалант хийдийн барилгыг биологийн эрсдэлээс хамгаалах төслүүдийг хийж гүйцэтгэсэн байна.

Бид татвар, хураамж, шимтгэлийн төлбөрөө жил бүр нэмэгдүүлж, улсын төсвийн бүрдүүлэлтэд бодитой хувь нэмэр оруулсан үзүүлэлтээр хувийн хэвшлээ манлайлсан хэвээр байна. Сүүлийн 10 жилд улсын төсөвт нийт 2.7 их наяд төгрөгийн татвар, шимтгэл төвлөрүүлсэн бөгөөд өнгөрөгч 2019 онд 513 тэрбум төгрөгийн татвар шимтгэлийг төлсөн нь өмнөх оноос **174 тэрбум** төгрөгөөр өссөн үзүүлэлт юм.

М-Си-Эс Групп нь аливаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэл эрхлэгчдээ дэмжин бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг тэднээс худалдаж авахыг эрмэлздэг бөгөөд 2019 онд нийт **1.8 их наяд** төгрөгийн худалдан авалт хийснээс дотоодын 3200 аж ахуйн нэгж, байгууллага, 662 хувь хүнээс **1.2 их наяд** төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Ийнхүү бид “Дэлхийн хөгжлийг Монголдоо цогцлоох” эрхэм зорилгоо хэрэгжүүлэхдээ улс орны эдийн засгийн өсөлтөд дорвитой хувь нэмэр оруулахын зэрэгцээ эрүүл мэнд, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, инноваци, дэд бүтцийг хөгжүүлэхэд тууштай хөрөнгө оруулж хүн, нийгэм, хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулахыг эрхэм болгон ажиллаж байна.



Хүндэтгэсэн,  
М-Си-Эс Группийн Дэд Ерөнхийлөгч  
Д.Энхтүвшин

## М-СИ-ЭС ГРУППИЙН ТУХАЙ

1993 онд байгуулагдан эрчим хүчний зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллаж эхэлсэн М-Си-Эс компани өдгөө 10,000 орчим ажилтантай, бизнесийн олон салбарт үйл ажиллагаа эрхэлж, татвар, шимтгэл болон нийгмийн төлөөх үйлсээрээ дамжуулан айл өрх, аж ахуйн нэгж төдийгүй улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулагч, баялаг бүтээгч олон компанийг эгнээндээ нэгтгэсэн үндэсний томоохон группийн нэг болжээ.

М-Си-Эс Групп нь монгол хүн эх орондоо сайн ажиллаж, сайхан амьдрах боломжийг бүрдүүлэхийн төлөө бизнесийн олон салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ эрүүл мэнд, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулахын төлөө тууштай ажиллаж байна.

Бизнесийн чиглэл:

- Эрчим хүч
- Барилга, үл хөдлөх хөрөнгө
- Уул уурхай
- Мэдээлэл, харилцаа холбоо
- Өргөн хэрэглээний бараа
- Нийгмийн төслүүд

☎ 77778833

📍 М-Си-Эс Холдинг ХХК, Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж 19,  
Шангри-Ла оффис, 24 давхар


🌐 [www.mcs.mn](http://www.mcs.mn)

📘 MCSGroupOfficial

🐦 GroupMCS

🌐 MCS Group

📷 mcsgroupofficial



# ЭРХЭМ ЗОРИЛГО: “ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ МОНГОЛД” ҮНЭТ ЗҮЙЛС, БАРИМТЛАХ ЗАРЧИМ



## МЭРГЭШСЭН ӨНДӨР ЧАДАВХ

Мэргэжлийн өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг байнга хөгжүүлдэг



## БАГИЙН СЭТГЭЛГЭЭ

Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг буй болгон хамт олонтойгоо үр дүнтэй хамтран ажилладаг



## МАНЛАЙЛАЛ

Цаашдын ахиц, хөгжлийн боломжийг олж тодорхойлж, бусдадаа ойлгуулан дэмжлэгийг нь авч, тэднийг урам зоригжуулан, хамтдаа бодит үйл хэрэг болгодог



## ӨӨРИЙМСӨГ ҮЗЭЛ

Ажилдаа болон компанидаа өөриймсөг хандаж, сэтгэл гарган ажилладаг



## САНАЛ САНААЧИЛГА

Хөгжүүлэх, сайжруулах, асуудлыг шийдвэрлэх бүтээлч шийдэл, санал санаачилгыг байнга гаргадаг



## ҮНЭНЧ ШУДАРГА ЗАРЧИМ

Монгол Улсын хууль журмыг алхам тутамдаа дээдэлдэг, аливаад үнэнч шударга ханддаг



## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАРЧИМ

Нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэдэг, хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажилладаг

## БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг байна.
- Бид ажилтан хөгжиж, ахиж дэвших орчныг бүрдүүлж, ижил тэгш бололцоо олгоно. Ажилтны өсч хөгжих, дэвжиж дээшлэх нь тухайн хүний ур чадвар, гүйцэтгэл, оруулж буй хувь нэмэртэй шууд холбоотой байна.
- Бид сайн ажилчин, ажилтан, менежер төдийгүй сайн манлайлагч байхыг эрмэлзэж, үлгэр дууриал үзүүлнэ.
- Бид шинийг сэдэж, аливааг сайжруулах боломжийг цаг ямагт эрэлхийлнэ.
- Бид шинэ санаа, бүтээлч хандлагыг хөхүүлэн дэмжинэ.
- Бид хамгийн шилдэг шийдэл бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэнэ.
- Бид ажилдаа эзний сэтгэлээр хандаж, компанийн нэр хүнд, өмч хөрөнгийг хайрлан хамгаална.



- Өндөр чадавхи, олон ургальч санаа бодол бүхий гишүүдээс бүрдсэн, харилцан итгэлцэл, хүндлэлд суурилсан хамтын зүтгэл нь бидний тогтвортой амжилтын үндэс юм.
- Бид зах зээлийн шударга зарчимд тулгуурлан харилцан биенээ дэмжиж, нөхөж ажилласнаар улам их үр дүн гаргах боломж бололцоогоо нэмэгдүүлнэ.
- Бид зөв зүйлийг зөв арга замаар хийж, хэлсэн үгэндээ эзэн байж, үүрэг хариуцлагаас зайлсхийлгүй, итгэл найдвар хүлээж ажиллана.
- Бид ажилтан, түнш, хэрэглэгчтэйгээ харилцахдаа үнэнч шударга зарчмыг эрхэмлэнэ.
- Бид нийгэмдээ болон байгаль орчиндоо ээлтэй байхыг эрхэмлэнэ.
- Бид хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд хангаж ажиллана.

Бид алхам тутамдаа М-Си-Эс-ийн үнэт зүйлс, баримтлах зарчмуудыг дээдэлнэ.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

Манай үнэт зүйлсийн нэг болох Тогтвортой хөгжлийн үзлийг бид бизнесийн үйл ажиллагаа, нийгмийн хариуцлагын үйлсдээ мөрдлөг болгон ажиллахын зэрэгцээ сайн засаглал бүхий төрийн бус байгууллагуудтай түншлэн нийгмийн төлөөх төсөл хөтөлбөрүүдээ илүү үр өгөөжтэй, өргөн цар хүрээтэй хэрэгжүүлэхийг зорьдог.

М-Си-Эс Групп нь Тогтвортой хөгжлийн зорилтууд, түүн дотроос дараах 10 зорилтыг онцлон, хэрэгжилтийг нь хангахад чиглэсэн үйл ажиллагааг түлхүү хэрэгжүүлж ирсэн.

Үүнд:

- Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих
- Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх
- Эрүүл мэндийг дэмжих
- Чанартай боловсролыг дэмжих
- Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх
- Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах
- Хариуцлагатай хэрэглээг дэмжих
- Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах
- Хуурай газрын экосистемийг хамгаалах
- Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх

## ЭРҮҮЛ МЭНД

Компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд эрүүл мэндийн салбарт нийт **1.2 тэрбум** гаруй төгрөгийн хандив тусламж өгч, шинэ технологийг нэвтрүүлжээ.

### БЯЦХАН ЗҮРХ ТӨСӨЛ

Энержи Ресурс компани зүрхний төрөлхийн эмгэгтэй хүүхдүүдийн эмчилгээнд зориулан Монголын Улаан Загалмай Нийгэмлэгт нийт **920 сая** төгрөг хандивласан. Уг төслийн үр дүнд зүрхний төрөлхийн эмгэгтэй 40 хүүхэд БНХАУ-д шаардлагатай хагалгаанд орж, эмчлэгдсэн. Хагалгааг хамгийн орчин үеийн дэвшилтэт аргачлалаар, биед зүсэлт, зовиур багатай технологиор хийсэн тул хүүхдүүд хурдан эдгэрч, тэнхэрч байна.



### ДУРАНГИЙН ХЭТ АВИАН ОНОШИЛГООГ МОНГОЛД АНХ УДАА НЭВТРҮҮЛЭВ

Эх орондоо олон улсын жишигт хүрсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан Интермед эмнэлэг нь Монгол Улсаас анх удаа олон улсын JCI магадлан итгэмжлэлийг авсан эмнэлэг бөгөөд орчин үеийн



оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, арга, техникийг нутагшуулахын төлөө сургалт, судалгаа, хөрөнгө оруулалтыг тасралтгүй хийсээр ирсэн. Үүний тод жишээ нь өнгөрсөн 2019 онд **600 сая** төгрөгийн хөрөнгө оруулалтаар дурангийн хэт авиан оношилгооны аппаратыг анхлан нэвтрүүлсэн явдал юм. Өмнө нь дурангийн хэт авиан оношилгоо, шинжилгээг Монгол Улсад хийдэггүй байсан тул иргэд шаардлагатай тохиолдолд Япон, БНСУ зэрэг орон руу явж оношлуулдаг байсан юм. Энэхүү технологийг нэвтрүүлснээр гадны орон руу явж, өндөр өртөгтэйгээр шинжилгээ хийлгэхгүй, эх орондоо оношлуулж эмчлүүлэх боломж бүрдсэн байна.

## ЭРҮҮЛ МЭНД

### ГОВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ЭМНЭЛГИЙГ НЯРАЙН НЭН ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖӨӨР ХАНГАХ ТӨСӨЛ

Энержи Ресурс компани “Эрүүл Үрс - Гэрэлт Ирээдүй” ТББ-ын хэрэгжүүлсэн “Говийн бүсийн аймгуудын эмнэлгийг нэн шаардлагатай нярайн тоног төхөөрөмжөөр хангах төсөл”-ийг дэмжин нийт

**370 сая** төгрөг хандивлалаа. Төслийн хүрээнд Говьсүмбэр, Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгуудын нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгуудад нярайн шарлагын аппарат, инкубатор, дуслын аппарат, билиметр зэрэг нэн шаардлагатай ч төсвөөс олдоц, хүрэлцээ муутай байдаг тоног төхөөрөмжүүдийг нийлүүлсэн.



### ЯВУУЛЫН ЭМНЭЛЭГ ТӨСӨЛ

Монгол орны хувьд тархан суурьшсан, эмнэлгийн дэд бүтцээс хол оршин суудаг иргэддээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, оношилгоог хүргэх чухал ач холбогдол бүхий “Явуулын эмнэлэг” төслийг хэрэгжүүлдэг. Энэ төслийн хүрээнд эхо, цус болон шээсний шинжилгээг газар дээр нь хийх зөөврийн төхөөрөмжөөр тоноглогдсон Интермед явуулын эмнэлэг 2019 оны 9 дүгээр сарын 13-20-ны өдрүүдэд Баянхонгор аймгийн Баянхонгор, Эрдэнэцогт, Гурванбулаг, Заг, Жаргалант, Галуут, Баян-Овоо сумдад ажиллаж, үнэ төлбөргүй үзлэг шинжилгээ хийсэн. Төслийг бүрэн хэрэгжүүлэхэд нийт 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд эхний ээлжинд **150 сая** орчим төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Мөн Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран цус, шээсний олон төрлийн шинжилгээг богино хугацаанд газар дээр нь хийж 1200 орчим иргэнд үйлчилсэн.



## ЭРҮҮЛ МЭНД

### БИЕЭ ХАЙРЛААРАЙ ХӨТӨЛБӨР

Юнител компани Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг болон Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн төвтэй хамтран Дархан хотын 3500 гаруй иргэнд хүн амын дунд өвчлөл өндөр байдаг 12 өвчний чиглэлээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг үнэ төлбөргүй хийхэд зориулж 24 сая төгрөг зарцуулсан.



### 1000 ХҮҮХДИЙН ЦАСНЫ БАЯР

Скай Резорт компани 2018 оноос уламжлал болгон эмзэг бүлгийн хүүхдүүдэд зориулан 1000 хүүхдийн цасны баярыг зохион байгуулж байна. 2019 онд Монголын Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран амьжиргааны түвшнөөс доогуур бүлгийн хүүхдүүд, тэдгээрийн гэр бүлийн нийт 1000 хүнд цана, чарга, тубинг, хөгжөөнт тоглоомын талбай, хөгжим тайз аппаратур, ресторан зэргээр үнэ төлбөргүй үйлчилсэн.



### ИВЭЭН ТЭТГЭЛГИЙН ХӨТӨЛБӨРҮҮД:

М-Си-Эс Кока Кола компани Улсын 3-р эмнэлэг, ЭХЭМҮТ, ЦСҮТ зэрэг эмнэлгийн байгууллагуудад хэвтэн эмчлүүлж буй болон цусаа хандивлахаар ирсэн иргэдэд сэтгэлийн дэм болгон 3.5 сая төгрөгийн нэрийн бүтээгдэхүүнийг хандивлав.

## БОЛОВСРОЛ

Бид өнгөрсөн онд нийслэл хот болон орон нутгийн цэцэрлэгийн хүүхдүүд, ерөнхий боловсролын энгийн болон тусгай сургуулийн сурагчид, оюутан, залууст чиглэсэн төрөл бүрийн хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж, боловсролын салбарт **360 сая** гаруй төгрөгийн хувь нэмэр оруулжээ.

### ОРОН НУТГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Энержи Ресурс компани Өмнөговь аймгийн Цогтцэций сумын “Мөрөөдөл” 2-р сургууль болон Т.Борын нэрэмжит ЕБС-д менежментийн болон математикийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, Улаанбаатар хотоос математикийн багш нэмэлт гэрээгээр ажиллуулан сумын нийт багш нарыг ур чадвар, заах арга зүйн мэргэжлийн сургалтуудад тогтмол хамруулж, урамшууллын системийг хэрэгжүүлснээр сурагчдын сурлагын үзүүлэлтэд ахиц гарч эхэлсэн байна.



## БОЛОВСРОЛ

### АМРАЛТААРАА АЖИЛЛАЯ ЦАЛИНТАЙ ОЮУТАН ХӨТӨЛБӨР

Энержи Ресурс компани Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханхонгор, Баян-Овоо, Цогт-Овоо сумын оюутан, залууст ажил эрхлэх, нэмэлт орлого олох боломж олгох, тэдний хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготойгоор уг хөтөлбөрийг хоёр дахь жилдээ хэрэгжүүлж байна. 2019 онд Ухаа худаг уурхайн 11 алба нэгжид нийт 42 оюутныг мэргэжлийн чиглэлийнх нь дагуу дадлагажуулан ажиллуулж, цалинжуулсан.



### НОГООН ЗҮРХ АЯН

Юнител компани Монголын Паралимпийн холбоотой хамтран паралимпийн тамирчдыг бэлтгэл сургуулилтаа хийх боломж бололцоогоор хангахын тулд Нийслэлийн тусгай 70-р сургуулийн спорт заалыг олон улсын стандартад нийцүүлэн засч, тохижуулахад **100 сая** төгрөг зарцуулжээ.



## БОЛОВСРОЛ

### U-MARKETER ХӨТӨЛБӨР

Юнител компанийн U хөтөлбөрийн хүрээнд 16-23 насны 500 гаруй залуучуудад ажлын туршлага, мэргэжлийн диплом шаардахгүйгээр маркетингийн төсөл хэрэгжүүлж, өөрсдийгөө сорих боломж олгосон. Ингэснээр тэдгээр залуучууд шинэ залуу маркетер болох үүдээ нээж, сургуулиа төгсөөгүй ч цалинтай ажиллаж нэмэлт орлого олсон юм.



### ХҮҮХДИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЦЭВЭРЛЭГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭ

Мэргэжлийн цэвэрлэгээ, кэмп, катерингийн үйлчилгээ үзүүлдэг Юнисервис солюшн компани Монголын Хүүхдийн Ордны хүүхдүүдэд багаас нь цэвэр цэмцгэр байдал, ариун цэврийн ач холбогдлыг сурталчлан таниулах зорилгоор ариун цэврийн өрөөнд иж бүрэн засвар хийж, гурван удаагийн хулдаасан шал өнгөлгөө, хоёр удаагийн чулуун шал өнгөлгөө хийсэн. Мөн орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулан Өмнөговь аймгийн Цогтцэций сумын цэцэрлэг, сургуульд иж бүрэн засвар хийж, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан ажиллаж байна.



## БОЛОВСРОЛ

### HAPPINESS CENTER

М-Си-Эс Кока-Кола компани нь хүүхэд залуусын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, хувь хүний хөгжилд чиглэсэн сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн Happiness center-ийг 2012 оноос ажиллуулж байна. Тус төвд лекц семинар зохион байгуулах танхим, сонирхсон номоо унших номын булан, авьяас чадвараа хөгжүүлж бэлтгэл сургуулилт, тоглолт хийх тайз, тоног төхөөрөмжөөс гадна үнэ төлбөргүй Wi-Fi орчин, X-BOX тоглоомууд бий.

2019 онд тус төв нь 35 байгууллагатай хамтран 204 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулж, нийт 30 мянга орчим хүнд хүрч үйлчилсэн байна.



### М-СИ-ЭС КОКА КОЛА КОМПАНИЙН БУСАД ИВЭЭН ТЭТГЭЛГИЙН ХӨТӨЛБӨРҮҮД:

- TEDxUlaanbaatar арга хэмжээ
- Unread-Unplug арга хэмжээ
- 29-р тусгай сургуулийн хүүхдүүдэд Олон улсын хүүхдийн баяраар гарын бэлэг
- БЗД-ийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олон улсын хүүхдийн баяраар гарын бэлэг

# НИЙГМИЙН ТӨСЛҮҮД

## УРЛАГ СОЁЛ, СПОРТ


### ӨВ ЭРДЭНЭ СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР

М-Си-Эс Групп нь Монголын Урлагийн Зөвлөлтэй хамтран үндэсний өв соёл, үнэт зүйлсийн бэлгэ тэмдэг болсон түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалах зорилготой “Өв Эрдэнэ” соёлын өвийн тэтгэлэгт хөтөлбөрт үндэсний хэмжээний томоохон төслүүдийг шалгаруулан, таван жилийн хугацаанд нийт **2 тэрбум** төгрөгийн санхүүжилт олгох юм.

Хөтөлбөрийн хүрээнд 2019 онд дараах төслүүдийг бүрэн гүйцэтгэж дууслаа.

Чойжин ламын сүм музейн орчны тохижилтын төсөл **(400 сая төгрөг)**

- Музейн гадна талбайн тохижилт
- Явган хүний зам
- Фасадны гэрэлтүүлэг
- Хэрмэн хашаа доторх зүлэгжүүлэлт
- Зүлэг усалгааны систем



# НИЙГМИЙН ТӨСЛҮҮД

## УРЛАГ СОЁЛ, СПОРТ

Амарбаясгалант хийдийн барилгыг биологийн эрсдэлээс хамгаалах төсөл (112 сая төгрөг)

- Хийдийг гамшгаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын хор 147 ширхэг, галын сараа 2 ширхэг зэрэг багаж хэрэгслээр хангасан
- Нийт 28 дуганы дээвэрт ургасан зэрлэг ургамал, бусад биологийн бохирдлыг цэвэрлэсэн
- Нийт 28 дуганы дээврийг шувуунаас хамгаалан торлох зэрэг ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн.



Богд хааны ордон музейн эрсдлийн нөлөөллийн судалгаа төсөл (66 сая төгрөг)

Тус төслийн хүрээнд Богд хааны ордон музейн түүх соёлын дурсгалт барилгад сэргөөр нөлөөлөх байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой геологийн хүчин зүйлс, геологи орчны бүтэц бүрэлдэхүүн, түүний физик, механик шинж чанар нөхцлийг тодорхойлон түүх соёлын дурсгалт барилга, түүний хадгалалт хамгаалалт сэргээн засварлалтад чухал шаардлага бүхий санал, зөвлөмжүүдийг багтаасан судалгааны эмхэтгэл ном хэвлэгдэн гарсан.

## УРЛАГ СОЁЛ, СПОРТ

### САГСАН БӨМБӨГИЙН 3Х3 ТӨРЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

М-Си-Эс Кока-Кола компани 2005 оноос Спрайт брэндийн нэрэмжит сагсан бөмбөгийн 3х3 тэмцээнийг зохион байгуулж, уг спортыг үндэсний хэмжээнд хөгжүүлж, улмаар олон улсын тавцанд гаргах хүртэл нийт **3.7 тэрбум** төгрөгийг зарцуулсан.

Энэ хугацаанд жилд дунджаар 10,000 гаруй хүүхэд залуус Спрайт лиг болон Спрайт 3х3 тэмцээнүүдэд оролцсон байна. Эдгээр тэмцээнүүдэд оролцож ирсэн залуус өдгөө амжилт үзүүлэн дэлхийн тавцанд эх орныхоо нэрийг бахархалтайгаар өргөж буйн тод жишээ нь “Улаанбаатар ММС Энержи” баг юм.

Энержи Ресурс компани ивээн тэтгэгчээр ажиллаж буй “Улаанбаатар ММС Энержи” баг гурван жил дараалан ФИБА 3х3 Ази тивийн аварга шалгаруулах тэмцээний шигшээ тоглолтонд шалгаран нэг алт, хоёр мөнгөн медаль хүртсэн. Түүнчлэн Токио-2020 зуны Олимпод 3х3 сагсан бөмбөгийн эмэгтэй баг тамирчид оролцох эрх авснаар Монгол Улс анх удаа багийн спортоор олимпид оролцох эрхийг авсан түүхэн амжилтыг бүтээгээд байна.

### FIBA 3X3 U18 WORLD CUP

М-Си-Эс Кока-Кола компани 2019 оны 6 дугаар сард сагсан бөмбөгийн 3х3 төрлийн гурван том тэмцээнийг Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор, Монголын 3х3 сагсан бөмбөгийн холбоо, М-Си-Эс Группийн дэмжлэгтэйгээр анх удаа эх орондоо зохион байгууллаа.

Уг тэмцээнийг зохион байгуулж, ивээн тэтгэхэд М-Си-Эс Кока-Кола компани **157 сая**, Юнител компани **83 сая** төгрөг зарцуулсан бөгөөд тэмцээнд оролцогчдыг Шангри-Ла зочид буудал хөнгөлөлттэй үнээр байрлуулсан байна.

## УРЛАГ СОЁЛ, СПОРТ

Уг дэлхийн аваргын тэмцээнийг буухиалж ФИБА 3x3 төрлийн 23 хүртэлх насны үндэстнүүдийн лигийн тэмцээн /U23 Nations League/ болон ФИБА 3x3 Улаанбаатар дэлхийн Гранпри тэмцээнүүд Сүхбаатарын талбайд зохион байгуулагдлаа.

Дээрх гурван тэмцээнд 34 орны шилдэг 40 багийн 500 гаруй тамирчин оролцсон бөгөөд Олон улсын сагсан бөмбөгийн холбооны 3x3 төрөл хариуцсан гүйцэтгэх захирал Алекс Санчес, хөгжил хариуцсан менежер Роберт Реблингер нар хүрэлцэн ирсэн нь уг тэмцээний ач холбогдлыг олон улсад өндөрөөр үнэлж буйн тод илрэл болсон юм.



# НИЙГМИЙН ТӨСЛҮҮД

## УРЛАГ СОЁЛ, СПОРТ

### ИД ШИДИЙН ОРОН

Хүүхэд хамгаалал, хөгжлийн “Ид шидийн орон-2” төслийн анхны хандивлагч нь Энержи Ресурс компани болж нийт зардлын 50 хувь буюу **760 сая** төгрөгийн санхүүжилт олгосон юм.

Энэ үйл хэргийг М-Си-Эс Группийн бусад компаниуд буухиалан дэмжиж М-Си-Эс Кока-Кола компани тус төвийн хүүхдүүдэд 1 сая орчим төгрөгийн үнэ бүхий шинэ жилийн баярын бэлэг гардуулж, Скай Резорт компани тус төвийн ажилтнууд, хүүхдүүд нийлсэн 50 хүнд 100 хувь хөнгөлөлт буюу 750 мянган төгрөгийн бодит хөнгөлөлт үзүүлсэн.

Мөн Анунгоо компанийн ажилтнууд өглөөний унд бэлдэн худалдан борлуулж, цугларсан 1.8 сая төгрөгийг хандивласнаар “Ид шидийн орон” төсөлд группийн компаниуд нийт **764 сая** төгрөгийн хандив, дэмжлэг өгчээ.



## БУСАД ТӨСӨЛ, ИВЭЭН ТЭТГЭЛЭГ:

### УХАА ХУДАГ НААДАМ

Энержи Ресурс компани орон нутгийн иргэдэд хүндэтгэл үзүүлэх, соёлын өв, уламжлалт ёс заншлыг түгээн дэлгэрүүлэх зорилготойгоор жил бүр Ухаа худаг наадмыг зохион байгуулдаг.


2019 онд нийт **400 сая** төгрөгийн зардлаар “Ухаа худаг-2019” наадмыг Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдыг хамруулан Цогтцэций суманд зохион байгуулсан. Тус наадамд хүчит 128 бөх, өсвөрийн 32 бөх барилдаж, таван насны хурдан морьд уралдаж, халх сурын харваанд 133 эрхий мэргэн харваач цэц мэргэнээ сорьсон байна. Түүнчлэн "Говь шанхын уртын дууны уралдаан", "Үндэсний хувцастай сайхан хос" зэрэг нутгийн соёлын өвийг сурталчилсан арга хэмжээнүүд зохиогдсоноос гадна орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчид худалдаа арилжаа хийж, бизнесийн орлогоо нэмэгдүүлсэн өргөн дэлгэр сайхан наадам болсон.



### XMF – ХУУР MUSIC FESTIVAL

М-Си-Эс Кока-Кола компани 2019 оны 8 дугаар сард зохион байгуулагдсан XMF – Хуур Music Festival хөгжмийн наадмын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллан 20 сая төгрөгөөр ивээн тэтгэсэн.

Олон улсын хөгжмийн наадмын стандартыг Монголдоо нэвтрүүлэх, нийгэмд эерэг мессеж түгээх, хөгжимд хайртай олон мянган залуусыг нэгтгэх, цаашлаад төв Ази, бүс нутгийн жуулчдыг татах зорилготой тус наадамд 50 мянга гаруй залуус оролцсон байна.





### ДАНИЙН ХААНЫ БАЛЕТ

М-Си-Эс Групп нь сонгодог урлагийг сурталчлан, дэмждэг уламжлалт үйл хэргээ үргэлжлүүлэн дэлхийд алдартай “Данийн хааны балет”-ын тэргүүн гоцлоочдын Улаанбаатар хотод хийсэн тоглолтыг дэмжиж, 10 сая төгрөгөөр ивээн тэтгэв.

## ОЛОН НИЙТИЙГ ЗӨВ ЗАН ҮЙЛД УРИАЛЦГААЯ

М-Си-Эс Группийн компаниуд нийгэмд тулгамдаж буй асуудлуудад анхаарлаа хандуулж, нийтээрээ нэгдмэл ойлголт, зорилгод нэгдэн нийгэмд эерэг, зөв зан үйлийг түгээх, уриалах, хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийлэл, гэмт хэргээс хамгаалахад чиглэсэн олон аян, кампанит ажлыг өрнүүлэн нийт **184 сая** төгрөг зарцуулжээ.




## ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Бизнесийн цар хүрээ тэлж, компаниуд маань өсч томрохын хэрээр нийгэм, улс орныхоо өмнө хүлээх бидний үүрэг, хариуцлага улам бүр өндөрсөж, дэлхийн стандарт, дэвшилтэт техник, технологийг эх орондоо нэвтрүүлж, нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон ажиллаж байна.

Өдөрт нэг тэрбум, сард 30 орчим тэрбум төгрөгийн татвар, шимтгэлийг улсын төсөвт төвлөрүүлж, өөрийн 10,000 ажилтандаа сард 16 тэрбум төгрөгийн цалин олгохоос гадна дотоодын 3000 орчим бизнес эрхлэгчээс сард 100 гаруй тэрбум төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авч, шууд бусаар мөн 20,000 хүнийг тогтмол ажлын байртай болгож, сард доод тал нь 20 орчим тэрбум төгрөгийн цалин тавих боломжийг олгон улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой, том хувь нэмрийг оруулж байна.

М-Си-Эс Группийн сүүлийн 10 жилд төлсөн татвар, шимтгэлийн нийлбэр дүн 2.7 их наяд төгрөг болж байна.



Дотоодын 3200 ААН, 662 хувь хүнээс

**1.2 ИХ НАЯД**

төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авсан байна.

М-Си-Эс Группийн компаниуд 2019 онд

**130 ТЭРБУМ**

төгрөгийн хөрөнгө оруулалт Монгол Улсын эдийн засагт оруулсан байна.

Шууд бий болгож байгаа ажлын байрны тоо

**10,000**



Шууд бусаар бий болгож байгаа ажлын байрны тоо

**20,000**



# БАЙГАЛЬ ОРЧИН

## АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ

Энержи Ресурс компани Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын утааг бууруулах ажлыг дэмжиж 2018 оноос эхлэн сайжруулсан түлшний түүхий эд болох Ухаа худагийн угааж баяжуулсан эрчим хүчний нүүрсийг Тавантолгой түлш компанид үнэ төлбөргүй нийлүүлж байна.

2019 онд нийт **11.7 тэрбум** төгрөг бүхий **710 мянган тонн** угааж баяжуулсан эрчим хүчний нүүрсийг нийлүүлжээ.

Ийнхүү Улаанбаатар хотын утааг багасгаж, агаарын бохирдлыг бууруулах үйлсэд бодитой хувь нэмэр оруулснаар нийслэлчүүдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх хангагдахад томоохон алхам хийгдлээ.



## НОГООН БАЙГУУЛАМЖ БИЙ БОЛГОХ

М-Си-Эс Интернэйшнл компани Ухаа худаг салбарын хэмжээнд цахилгаан станц болон дэд станцын орчмоор 2010 оноос хойш нийт 1.6 га талбайд ногоон байгууламж бий болгосон.



## “НОГООН БАЙГААСАЙ” ХӨТӨЛБӨР

Юнител компани нь Хоггүй Монгол ТББ-тай хамтран олон нийтийг хог хаягдлаа багасгах, дахин боловсруулах боломжтой бүтээгдэхүүнийг ашиглах, хогоо ангилж сурах болон хаягдал бага үүсгэх бүтээгдэхүүнийг ашиглахад уриалсан “Хаягдалгүй амьдаръя” аянг санаачлан сошиал хөдөлгөөн өрнүүлсэн.



## ДУГУЙН ЗОГСООЛ

Эрчим Сүлжээ компани ЭВА засварын төв болон Ньютушта майнинг компанитай хамтран Анун төвийн гадна өнгө үзэмжтэй нийцүүлэн унадаг дугуйн зогсоол бий болгосон. Ингэснээр Анун, Анунгоо, Эрчим сүлжээ, М-Армор, Тотал Дистрибьюшин компаниудын **500 гаруй ажилтнууд** өөрсдийн эрүүл мэндэд анхаарахаас гадна агаарын бохирдлыг бууруулах, авто замын түгжрэлийг арилгахад хувь нэмрээ оруулах боломжтой болсон юм.



## ЭРЧИМ ХҮЧ


М-Си-Эс Интернэйшнл компани Ухаа худаг салбар дахь цахилгаан станцын дотоод хэрэгцээний эрчим хүчний хэрэглээг бууруулахын тулд станцын тоноглолуудыг давтамж хувиргуураар тоноглосон.

Үүний үр дүнд цахилгаан станцын дотоод хэрэгцээг 10 хувиас хэтрүүлэлгүй ажиллаж байгаа нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бусад цахилгаан станцуудтай харьцуулахад харьцангуй сайн үзүүлэлт юм.



Энержи Ресурс компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг 24 цагийн найдвартай тог цахилгаанаар хангахын зэрэгцээ бусад сумдад доголдол үүссэн үед цахилгаанаар ханган ажилладаг.

Үүгээр зогсохгүй Даланзадгад сумын дулааны цахилгаан станц болон Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор зэрэг сумдад жил тутам 45,000 орчим тонн эрчим хүчний нүүрс үнэ төлбөргүй нийлүүлж байна.



## УСНЫ ХЭРЭГЛЭЭ

М-Си-Эс Групп 2019 онд нийт **1 сая тонн** усыг дахин ашигласан байна.

Зам талбай, ногоон байгууламжийн усалгаа

**80%**

Нүүрсний талбайн усалгаа

**16%**

Машин угаалга

**4%**

## ХАЯГДАЛ УС ЦЭВЭРШҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖ

М-Си-Эс Кока-Кола компанийн Хаягдал ус цэвэршүүлэх байгууламж нь 2019 онд “Хүрээлэн буй орчинд нийлүүлэх Цэвэршүүлсэн бохир ус” ерөнхий шаардлага MNS 4943-2015 стандартыг бүрэн хангасан

**200 гаруй мянган тонн** ус цэвэршүүлж, нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх, ногоон байгууламжийг услах зорилгоор “Улаанбаатар хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-т **4500 тонн** ус өгсөн бол компанийн түгээлтийн машинуудын угаалга, ногоон байгууламжийн усалгаанд **2200 тонн** орчмыг ашигласан байна.



## ЦАХИЛГААН СТАНЦЫН ТЕХНОЛОГИЙН УСЫГ ДАХИН АШИГЛАЖ БАЙНА

М-Си-Эс Интернэйшнл компани Ухаа худаг дахь цахилгаан станцын технологийн усыг төслийн талбайн хөнгөн тэрэгний зам болон уурхайн технологийн зам усалгаа, станцын гадаад талбайн ногоон байгууламжийг услахад дахин ашигласан байна.



### ХӨРСНИЙ БОХИРДЛООС СЭРГИЙЛЭХ

М-Си-Эс Интернэйшнл компанийн Ухаа худагийн цахилгаан станцад түлш болон хаягдал тосны хадгалалтаас үүсч болзошгүй бохирдлоос урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна. Хөрс бохирдуулж болзошгүй цэгүүдээс дээж авч, микроэлементийн шинжилгээ хийлгэж, стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. Мөн хаягдал тос хадгалах цэгийг цэвэрлэж, хашаатай болгож хяналтыг сайжруулсан.



# М-СИ-ЭС ГРУППИЙН АЖИЛТНУУД

Нийт ажилтнуудын тоо 2019 онд 8 хувь өссөн.



- Хөндлөн шилжилт хийсэн ажилтны тоо
- Дэвшин ажилласан ажилтны тоо



# М-СИ-ЭС ГРУППИЙН АЖИЛТНУУД

## М-СИ-ЭС АКАДЕМИ

СУРГАЛТЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛҮҮД:

- Манлайллын багц хөтөлбөр
- М-Си-Эс Менежмент хөтөлбөр
- Хувь хүний хөгжил
- Менежерийн хөгжил
- Чиг үүргийн хөгжил
- Ажилтны хөтөлбөр

2019 онд М-Си-Эс Академийн зохион байгуулсан нийт 2458 сургалтанд давхардсан тоогоор 12726 ажилтан хамрагдаж, үүнд 2.2 тэрбум гаруй төгрөг зарцуулсан байна.

Группийн дотоодоос 40 гаруй сургагч багш байгаагаас 70 хувь нь эмэгтэй, 30 хувь нь эрэгтэй ажилтан байна. Мөн дотоод сургагч багш нарын 70 хувь нь менежер, удирдах түвшний ажилтнууд байна.



### БИД САЙН ДУРЫН АЖЛЫГ ДЭМЖИГЧ

ESV (Employer Supported Volunteering) буюу ажил олгогчийн дэмжлэгтэйгээр ажилтнууд өөрийгөө хөгжүүлэх болон бусдын сайн сайхны төлөө сайн дурын үйл хэрэгт оролцох санаачилгыг дэмжин, ажилтан сайн дурын ажилд оролцох тохиолдолд жилд нэг удаа цалинтай чөлөө олгох журмыг батлан хэрэгжүүлж байна. 2019 онд М-Си-Эс Группийн нийт 166 ажилтан 1392 цагийг сайн дурын ажилд зарцуулсан байна.

Тотал Дистрибьюшин компанийн 14 ажилтан 186-р тусгай цэцэрлэгт 60 метр урт хөтөч шар зам суурилуулж, сонсголын хичээлд шаардлагатай хөгжим, тоног төхөөрөмж бэлэглэсэн.



Эрчим Сүлжээ компанийн 55 ажилтан Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Эрчим төгөл” бий болгож, 2018 оноос хойш нийт 100 ширхэг гацуур, 100 ширхэг навчит мод, хус, улиас зэргийг тарьж, арчилж, ургуулж байна.



Анунгоо компанийн 98 ажилтан 116 дугаар тусгай сургуульд аутизмын эмгэгтэй хүүхдүүдэд зориулсан тусгай өрөөг засч тохижуулж өгсөн.



### ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

М-Си-Эс Группийн хэмжээнд нийт 50 хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнууд ажиллаж байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнууд жилд хамгийн багадаа 1 удаа хурал, уулзалт зохион байгуулж өөрсдийн компанийн сайн туршлага, сургамжтай кейс болон цаашид хэрэгжүүлэх ажлын зорилго, зорилтын талаар хэлэлцэж, санал бодлоо солилцдог.



Бид бүх осолд дөхсөн тохиолдол болон бодитой осол зэргийг мэдээлж, бүртгэн судалдаг. Ингэснээр осол бүрд тохирсон хариу арга хэмжээг авч дахин осол гарахаас сэргийлэх, жил бүрийн зорилтоо тодорхойлох, тасралтгүй сайжруулалтыг хийхэд дөхөм болдог.

Группийн хэмжээнд нийт бүртгэгдсэн осол, бэртлийн тоо өнгөрсөн онтой харьцуулахад **49 хувиар** буурсан байна.

Ослын тоог бууруулахад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх сургалтын арга хэмжээ чухал үүрэгтэй учраас 2020 онд сургалтын чанарыг сайжруулах, арга хэлбэрт шинэчлэл хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдлэгийн шалгалтын материалыг шинэчлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллахаар төлөвлөж байна.

2019 онд М-Си-Эс Группийн хэмжээнд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийт 1130 цагийн сургалтад давхардсан тоогоор 7031 ажилтан хамрагдсан байна.

## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

М-Си-Эс Групп нь бүх ажилтнууд, туслан гүйцэтгэгчдийн эрүүл, аюулгүй байдлыг ханган ажиллахыг зорьдог ба үүний хүрээнд аюулгүй ажиллагааны дүрэм журмыг боловсруулан үйл ажиллагааг системчлэх, аюулгүй ажиллагааны соёлыг бэхжүүлэх, Олон улсын туршлагыг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг тасралтгүй сайжруулан хийж байна.

Группийн компаниуд Монгол Улсын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд дагаж, мөрдөгддөг хууль, дүрэм, журам, стандартууд болон ISO 45001, ISO 9001 зэрэг олон улсын стандартуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2019 онд шинээр нэвтрүүлсэн технологи болон стандартуудаас дурдвал:

### МЭДЛЭГИЙН ШАЛГАЛТ

М-Си-Эс Интернэйшнл компани Монгол улсад мөрдөгддөг “Аюулгүй ажиллагааны дүрэм”, “Техник ашиглалтын дүрэм”-ийн мэдлэгийн шалгалтыг инженер, техникийн ажилтнуудаас цахим хэлбэрээр авч эхлээд байна. Ингэснээр ажилтнуудын мэдлэгийн түвшинг бодитоор үнэлэх, цаг хугацаа хэмнэх зэрэг давуу тал үүссэн юм.

### ТУСГААРЛАЛТЫН ЖУРАМ

М-Си-Эс Интернэйшнл компани Эрчим хүчний салбарт өмнө учирч байсан болон тохиолдох боломжтой эрсдэлүүдийн мэдээлэл, түүнээс авсан сургамжид үндэслэн Тусгаарлалтын журмыг нэвтрүүлсэн. Энергийн эх үүсвэрийг бүрэн тусгаарлаж салгасныг баталгаажуулах нь ажилтанд ажлаа аюулгүй гүйцэтгэх боломжийг бий болгодог.



### НҮД УГААГЧ ШҮРШҮҮР БОЛОН СОРОНЗОН ТАВИУР

Интермед эмнэлэг нь түргэний машин, MSDS өрөө, хог хаягдлын байр, ханган нийлүүлэхийн байр зэрэг нүд угаах шүршүүргүй цэгүүдэд нийт 28 ширхэг нүд угаах шүршүүрийг уусмалын хамт байрлуулсан. Мөн хагалгааны өрөөнүүдэд хурц иртэй багаж хэрэгсэлүүдийг аюулгүй дамжуулах нэг удаагийн соронзон тавиуруудыг байрлуулсан байна.





**ДЭЛХИЙН ХӨГЖЛИЙГ МОНГОЛД**